

МОНГОЛЫН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ХӨГЖИЛД ЯПОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ ДЭМЖИХ НЬ

Ж. Уянга*

1990 онд Монгол орон зах зээлийн эдийн засагтай ардчилсан нийгмийн тогтолцоонд шилжин орсноор аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх шинэ үеийг нээж өгсөн юм. Дэлхийн аялал жуулчлалын салбар дахь Монгол улсын оролцоо жилээс жилд нэмэгдэж байна. XXI зуунд Монгол улсыг дэлхий дахинд сурталчилах, ажлын байрыг хамгийн ихээр бий болгох, үр ашиг өндөр, дэлхийн улс орнуудын ард иргэдийг харилцан ойртуулж нягтруулах гол хэрэглүүр бол аялал жуулчлалын салбар юм. Тиймээс Монгол улсын Засгийн газар ихээхэн ач холбогдол өгч үйл ажиллагааныхаа мөрийн хөтөлбөрт аялал жуулчлалын салбарыг улс орны эдийн засгийн нэгэн тэргүүлэх чиглэл болгон хөгжүүлэхээр заасан билээ. Үүний хүрээнд Монгол оронд аялал жуулчлалыг 2015 он хүртэл хөгжүүлэх Мастер төлөвлөгөө салбарын бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, аялал жуулчлалыг хөгжүүлэх хууль эрх зүйн болон бизнесийн таатай орчинг бүрдүүлэх зэрэг тодорхой асуудлуудыг Европын холбоо болон Япон улсын засгийн газрын дэмжлэгтэйгээр 1999 онд боловсруулсан юм.

Өнөө үед гадаадын хөрөнгө оруулагчид зөвхөн ашиг орлого олох боломжтой газар төдийгүй хөрөнгө оруулалтын илүү найдвартай, аюулгүй орчин бүхий улс орныг сонгох болсон. Монгол улсын засгийн газар “Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль”-ийг УИХ-р хэлэлцүүлэн 1991 онд анх баталж 1993, 1998 болон 2002 онуудад нэмэлт өөрчлөлтүүд оруулсан бөгөөд эдгээр нь хөрөнгө оруулалтын илүү тааламжтай орчныг бий болгоход чиглэгдсэн юм. Одоогоор гадаадын хөрөнгө оруулалттай 41 компани бүртгэгдээд байна.

Аялал жуулчлалыг хөгжүүлэх хууль эрх зүйн, эдийн засгийн бүх талын таатай орчинг бүрдүүлэхийн тулд 2000 онд УИХ-аас Аялал жуулчлалын хуулийг батлан гаргасан. Аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжийн эдийн засгийн чадавхийг дээшлүүлж, хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор Монгол улсын засгийн газраас уг салбар дахь аж ахуйн нэгжүүдийг Нэмүү Өртгийн Албан татвараас чөлөөлсөн нь аялал жуулчлалын хөгжилд бодитой дэмжлэгийг үзүүлж байгаа юм.

*Ж.Уянга - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

Одоогийн байдлаар Монгол улсад үзүүлж буй гадаадын тусламж хандивийн хэмжээгээр Япон улс тэргүүлдэг бөгөөд ХАА, дэд бүтэц, боловсролын чиглэлүүдээр томоохон төслүүдийг хэрэгжүүлсээр ирсэн билээ. Мөн түүнчлэн Гадаадын хөрөнгө оруулалт гадаад худалдааны агентлагийн судалгаагаар, Япон улс нь гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээгээр мөн тэргүүлэгч орнуудын эгнээнд багтдаг бөгөөд энэ хэмжээ нь өнөөдөр 50 сая ам.долларт хүрээд байна. Гэсэн хэдий ч аялал жуулчлалын салбар дахь хөрөнгө оруулалтын хэмжээ зөвхөн 2 хувьтай байгаа¹ бөгөөд энэ үзүүлэлтийг аялал жуулчлалыг хөгжүүлэх олон талт арга хэмжээг авсанаар нэмэгдүүлэх боломжтой гэж мэргэжилтнүүд үзэж байгаа юм.

Энэ зорилгоор хөрөнгө оруулалтыг хөхүүлэн дэмжих, гадаад улсуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх, Монгол улсыг дэлхий дахинд сурталчилах ажлыг эрчимжүүлэх зэрэг олон талт арга хэмжээг хэрэгжүүлж байна.

2001 онд манай улсад гадаадын 125 орноос нийт гийчин 192,051 иржээ. Тэдний 165,899 нь амралт чөлөөт цагаараа жуулчлах зорилгоор ирсэн байна. Үүний дотор Японы жуулчдын эзлэх хувь хөгжингүй орнуудаас ирж буй жуулчдын ихэнх хувийг эзэлж байна².

1990 оноос хойш Монголд ирсэн Японы иргэдийн статистик мэдээллээс үзвэл хоёр орны найрамдалт хамтын ажиллагаа сэргэн хөгжихийн хажуугаар Монголын өргөн уудам тал хээр нутаг, байгальдаа зохицон амьдрах нүүдлийн мал аж ахуйн амьдрал, монголчуудын зан заншилтай танилцах сонирхолтой жуулчдын тоо ч нэмэгдэж байна. Үүний нэг жишээ нь 1990 онд Монголд зочилсон Япон иргэдийн тоо 1,700 байсан бол энэ үзүүлэлт 2001 онд 11,473 болж өссөн байна. 2002 оны эхний 3 улирлын байдлаар Японы нийт 9,973 гийчид ирсэний ихэнх буюу 9,096 нь аялал жуулчлалын зорилгоор Монголд ирсэн байна³.

2002 оны 9 сарын байдлаар Монгол улсад аялал жуулчлалын ажил үйлчилгээ эрхлэх зөвшөөрөл бүхий 400 гаруй аж ахуйн нэгж, байгууллага, 16 аймгийн нутаг дэвсгэрт 5,900 жуулчин хүлээн авах хүчин чадал бүхий 118 орчим жуулчны бааз, 5,000 гаруй хүнийг хүлээн авах хүчин чадал бүхий 90 гаруй зочид буудал Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж байна⁴.

Одоогийн байдлаар гадаадын хөрөнгө оруулалттай аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулж буй 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллага бүртгэгдсэний 40 орчим хувийг Японы хөрөнгө

оруулалттай хувийн аж ахуйн нэгж, байгууллагууд эзэлж байгаа бөгөөд аялал жуулчлалын салбарт хувийн хэвшлийн оруулсан хөрөнгө оруулалтын нийт хэмжээ нь өнөөгийн байдлаар 1,428,958 ам.долларт хүрээд байна. Гадаадын техникийн болон санхүүгийн тусламжаар хэрэгжүүлэхээр ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсан 22.2 сая долларын өртөг бүхий төслүүдийг Хандивлагчдын ээлжит VIII зөвлөлгөөн, Япон улсын Засгийн газрын 2002 оны зээл тусламжаар хэрэгжүүлэхээр төлөвлөн Санхүү Эдийн засгийн яам болон холбогдох газарт санал болгоод байна⁵. Түүнчлэн МИАТ компани Япон улс руу өвлийн тогтмол нислэгтэй болсонтой холбогдуулан өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэхэд тоног төхөөрөмж нийлүүлэх хэлбэрээр хөрөнгө оруулалт оруулахад дэмжлэг тусалцаа үзүүлж байна. Мөн Улаанбаатар-Токио чиглэлийн шинэ нислэг нэмэгдсэн, бусад гадаад нислэгийн тос нэмэгдэж байгаа зэрэг нь манай оронд ирэх жуулчдын тоог өсгөх, түүнийг дагаад аялал жуулчлалын дэд бүтцийг сайжруулахад нэн чухал юм.

2001 онд манай орны аялал жуулчлалын салбарын бүтээгдхүүний борлуулалт 102,6 сая ам доллар болсон нь дотоодын нийт бүтээгдхүүнд эзлэх экспортын орлогын 10,2 %-ийг тодорхойлж байна⁶.

Манай аялал жуулчлалын зах зээлд голлох орон болдог Японы зах зээлд ихээхэн анхаарал тавьж, ач холбогдол өгөн ажиллаж байна. Өөрийн орныг Японы зах зээлд өргөн цар хүрээтэйгээр сурталчилан таниулах зорилгоор аялал жуулчлалын компаниудтай хамтран аялал жуулчлалын уулзалт семинаруудыг зохион байгуулах, Япон улсад жил бүр "Discover Mongolia", "Mongolian Tourism Day" аялал жуулчлалын үзэсгэлэн яармагуудыг зохион байгуулах зэрэг ажлууд хийгдэж байна. Японоос ирэх жуулчдад Монголын тухай мэдээллийг түргэн шуурхай хүргэхийн тулд япон хэл дээр вэб хуудас ажиллуулж, танилцуулгын материалыг япон хэл дээр хэвлэн гаргуулаад байна.

2002 оны 10-р сард Аялал жуулчлалын газраас МИАТ компани, Монгол-Японы төвтэй хамтран Японы аялал жуулчлалын 14 компанийн төлөөлөгчдийг хүлээн авч өөрийн орны тухай танилцуулсан юм. Энэ нь 2003 оныг Монголд зочлох жил болгосонтой холбогдуулан Японы жуулчдыг нэмэгдүүлэх зорилготой үйл ажиллагаа болсон юм⁷.

Түүнчлэн жуулчдад зөв оновчтой, түргэн шуурхай мэдээллийг өгөх, сурталчилгааг эрчимжүүлэн үр нөлөө, цар хүрээг өргөжүүлэхийн

тулд Аялал Жуулчлалын Газрын өргөмжит төлөөлөгчийн газрыг байгуулан ажиллаж байна⁸.

Хэдийгээр Монгол орныг гадаадад сурталчилахад ахиц ололт гарсаар байгаа ч бүрэн хангалттай хэмжээнд хүрсэн гэж үзэхгүй байна. Газар нутгийн байршлын болон бусад шалтгаануудаас одоог хүртэл дэлхий нийтэд бүрэн танигдаагүй, тэдний хүртээл болж чадаагүй улс орнуудын тоонд Монгол орон орсон хэвээр байна.

Энэ нь аялал жуулчлалын салбар эрчимтэй хөгжлийн замдаа орж чадаагүй нэгдсэн сүлжээ, зам харилцаа, дэд бүтэц хангалтгүй, мөн нислэгийн аюулгүй байдал, онгоцны хүчин чадал, олон улсын нислэгийн тоо хязгаарлагдмал, жуулчлалын улирал богино, үйлчилгээний түвшин доогуур, жуулчдад хүргэх сурталчилгаа, мэдээлэл дутмаг зэрэг хүчин зүйл монголын аялал жуулчлалын хөгжилд сөргөөр нөлөөлж байна.

Монголын аялал жуулчлалын хөгжлийг хурдасгах зорилгоор 2003 оныг “Монголд зочлох жил” болгон зохион байгуулж Монгол улсын Засгийн газраас ихээхэн хүч чармайлт тавин тодорхой бэлтгэл ажлуудыг төлөвлөн хэрэгжүүлж эхлээд байна⁹. 2003 оныг Монголд зочлох жил болгосноор Монголд ирэх нийт гадаадын зорчигчдын тоо урьдчилсан судалгаагаар 250 мянгаас хол давахаас 230 000 нь жуулчлах зорилгоор ирнэ гэж үзэж байна. Жуулчдаас Монгол улсын аялал жуулчлалын салбарт орох орлогын өсөлт, эдийн засгийн үр ашгийн урьдчилсан тооцоог үзвэл 2003 онд аялал жуулчлалын салбарын орлого 131.2 сая ам.доллар болж, ДНБ-ний 10.6%-г эзлэх бөгөөд одоогийнхоос даруй 26 сая ам.долларын орлогыг нэмж олох боломж бүрдэх юм¹⁰.

Түүнчлэн Ази, Номхон далайн эдийн засгийн интеграцчлалд Монголын хувьд ойрын үед нэгдэн орж болохуйц хамгийн ирээдүйтэй салбар болох аялал жуулчлалыг улам бүр хөгжүүлэх нь Ази, Номхон далайн бүс нутагт байр сууриа бататгаж, бүсийн эдийн засаг, улс төрийн интеграцчлалд идэвхтэй оролцоход чухал үүрэг гүйцэтгэх юм.

Ишлэл, зүүлт:

1. Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, АЖ-ын салбар хуралдааны товч тэмдэглэл, 2002.09.17
2. Аялал Жуулчлалын Газрын статистик мэдээлэл, 2002 он
3. Мөн тэнд
4. “Өнөөдөр” сонин 2002.10.19
5. Хөрөнгө оруулагчдын чуулга уулзалт, АЖ-ын салбар хуралдааны товч тэмдэглэл, 2002.09.17
6. Аялал Жуулчлалын Газрын статистик мэдээлэл, 2002 он
7. “Зууны мэдээ” 2002.10.21, №254 /1140/
8. Мөн тэнд
9. Монгол Улсын Гадаад Хэргийн яамны мэдээллийн товхимол, №14/122/, 2002он, 9 сар
10. Аялал Жуулчлалын Газрын статистик мэдээлэл, 2002 он